



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Өвөлжилтийн үеийн эмнэлгийн тусламж,  
үйлчилгээний бэлэн байдлыг хангах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 28 дугаар тогтоолыг үндэслэн бүс нутгийн онцлогт тохируулан 2024-2025 оны өвөлжилтийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу өөрийн орон нутгийн хэмжээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт ДААЛГАСУГАЙ.

**Нэг. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай нөөцийн бэлэн байдлыг хангах, төсвийн сахилга батыг сайжруулах чиглэлээр:**

- 1.1. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, болзошгүй нөхцөл байдал үүссэн үед ажиллах хүний нөөц, байр, эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, шатахууны нөөцийг тооцож, бэлэн байдлыг хангах;
- 1.2. Товлолт вакцины нөөц, хадгалалт, вакцины хөргөгчний хэвийн ажиллагаа, нөөц моторын бэлэн байдлыг хангаж ажиллах
- 1.3. Зайлшгүй шаардлагатай үед дайчлах санхүүгийн нөөцийг урьдчилан тооцоолсон байх;
- 1.4. Эмнэлгийн байгууллагын халаалтын асуудлыг бүрэн шийдвэрлэж, түлшний нөөцийг бүрдүүлэх, дулааны шугам, сүлжээний ээлжит засвар, үйлчилгээ, угаалга, туршилт, тохируулгыг цаг хугацаанд нь дуусгах;
- 1.5. Цахилгааны нөөц эх үүсвэрийн хэвийн үйл ажиллагааг шалгаж, бэлэн байдлыг хангах;
- 1.6. Яаралтай тусламжийн үед ашиглах зөөврийн тоног төхөөрөмжүүдийг бэлэн байлгах;
- 1.7. Барилга, их засвар, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьж, гэрээний хугацаанд ашиглалтад оруулах;
- 1.8. Эрүүл мэндийн байгууллагууд 2024 оны төсвийн жил дуусч буйтай холбогдуулан төсвийн сахилга, хариуцлагыг дээшлүүлж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн өр, авлагагүй ажиллах;

**Хоёр. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах чиглэлээр:**

- 2.1. Байгалийн болзошгүй аюулт үзэгдлийн үед өөрийн байгууллагын чиг үүргийн дагуу харьяа нутаг дэвсгэрт болон үндэсний түвшинд эмнэлгийн тусламж,

143240018

үйлчилгээг тасалдалгүй, чирэгдэлгүй үзүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах;

2.2.Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, хүчилтөрөгч, тоног төхөөрөмж, хоол хүнс, ундны ус, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл, өндөр тунт А аминдэмийн нөөцийг тооцож бэлтгэх, шаардлагатай тохиолдолд яаралтай татан авалт хийх, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурын чанарыг алдагдуулахгүйгээр тээвэрлэх, хадгалах, тараах нөхцөлийг бүрдүүлж, хяналт тавих;

2.3.Эмнэлэг хүртэлх тусламж, үйлчилгээ үзүүлэх тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг хийж, аюулгүй байдлыг ханган ажиллах;

2.4.Алсын дуудлагад томилолтоор ажиллах эрүүл мэндийн ажилтныг харилцаа холбоо бусад нэн шаардлагатай хэрэгслээр хангах;

2.5. Өвөлжилт хүндэрсэн үед жирэмсэн, төрсний дараах үе, нярай, хүүхдийн тусламж, үйлчилгээний төлөвлөлтийг хийж ажиллах.

**Гурав. Отор нүүдлээр явж буй малчдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр:**

3.1. Отор нүүдэл хийхээр төлөвлөж буй айл өрх, иргэний бодит тоо, отор нүүдэл хийх зураглалыг гаргаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар холбогдох аймаг, сумтай хамтран төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

3.2. Өвөлжилт хүндэрч болзошгүй баг, сум, аймагт амьдарч байгаа болон отор нүүдэл хийх айл өрхийн 5 хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хэвтрийн үйлчлүүлэгч, хөгжлийн бэрхшээлтэй иргэний бүртгэл хөтлөл, эрүүл мэндийн байдлыг хянаж, зөвлөмж өгөх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх шаардлагатай иргэнд хамгийн ойр эрүүл мэндийн байгууллагад үзүүлэх ажлыг зохион байгуулах;

3.3. Отроор өвөлжих малчдад эрүүл мэндийн тусламжийг явуулын багаар үзүүлэх хуваарь гаргах, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.4. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдээс баг томилж, өвөлжилт хүндэрсэн аймгуудад ажиллуулахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын газарт хариуцуулах /зөөврийн эхо, зүрхний бичлэгний аппарат, зүрхний эхо, зүрхний эмч, дотрын эмч зэрэг судалгааг авсан байх/;

3.5. Отор нүүдлээр өвөлжиж малчин өрхийн судалгааг Эрүүл мэндийн хөгжлийн төв нэгтгэн тус яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газарт ирүүлэх

**Дөрөв. Эрүүл мэндийн ажилтны сургалт, нийгмийн хамгааллыг хангах чиглэлээр:**

4.1.Эмнэлгийн мэргэжилтнүүдэд осголт, хөлдөлт, амилуулах суурь тусламж, томуу, томуу төст өвчин, Улаанбурхан, коронавируст халдвар (Ковид-19) халдвараас урьдчилан сэргийлэх, эмчлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

4.2.Зайлшгүй ажиллах шаардлагатай эмч, сувилагч, ажилтнуудын ээлжийн амралтыг зохицуулж, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс өмнө дуусгах;

**Тав. Мэдээлэл сурталчилгааг эрчимжүүлэх чиглэлээр:**

5.1. Хувийн бэлтгэлийг хангах, жирэмсэн эмэгтэй, бага насны хүүхдийг хараа хяналтгүй, орхихгүй байх, хөлдөлт, осголт, томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх

талаар иргэдийг бодит мэдээллээр тогтмол хангах, сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр сургалт зохион байгуулах;

5.2. Гадаад болон дотоод орчны агаарын бохирдлын өртөлтөөс сэргийлэх чиглэлээр иргэдэд зөвлөмж, мэдээлэл хүргэх;

5.3. Хүйтэн сэрүүний улиралд ахуйн галлагаатай холбоотойгоор угаартахаас сэргийлэх, анхны тусламж үзүүлэх зөвлөмжийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр тогтмол түгээх;

### **Зургаа.Орон нутгийн байгууллагуудтай хамтарч ажиллах чиглэлээр:**

6.1.Орон нутгийн Онцгой байдлын газар болон Ус цаг уурын албанаас цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг тогтмол авч, байгалийн болзошгүй аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

6.2.Эрүүл мэндийн байгууллагууд гадна орчныхоо зам талбайн цас, мөсийг цэвэрлэж, үйлчүүлэгчийн унаж бэртэхээс сэргийлж, аюулгүй орчныг бүрдүүлэх;

### **Долоо. Албан даалгаврын хэрэгжилтийг тайлагнах**

7.1 Албан даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр бэлэн байдлыг хэрхэн хангасан талаарх мэдээллийг 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор тус яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газарт ирүүлэх;

7.2. Аймаг, нийслэл, сумын өвөлжилтийн байдал, отор нүүдлээр явж байгаа болон өвөлжилт хүндэрсэн, зудтай бүс нутгийн айл өрх, иргэний бодит тоог 14 хоног тутамд нэгтгэн, сар бүрийн хоёр, дөрөв дэх долоо хоногийн Пүрэв гарагийн 17 цагаас өмнө Эрүүл мэндийн хөгжлийн төвийн [admin@hdc.gov.mn](mailto:admin@hdc.gov.mn) цахим хаяг руу хүргүүлж байх;

7.3. Эрүүл мэндийн хөгжлийн төв сар бүрийн нэгтгэлийг Эмнэлгийн тусламжийн газарт цахим хаягаар болон албан бичгээр ирүүлэх.

Хавсралт... хуудастай.

САЙД  Т.МӨНХСАЙХАН



Эрүүл мэндийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 2/ дугаар албан даалгаврын хавсралт.

**АЙМАГ, СУМДЫН ОТОР НҮҮДЛЭЭР ЯВАА ИРГЭДИЙН СУДАЛГАА**

**СУДАЛГААНЫ АСУУМЖ НЭГ.**

**2024 оны .. дүгээр сарын ... -ны байдлаар**

**/... дэх 14 хоногийн судалгаа/**

№	Аймаг, асуумж	Отроор өвөлжиж буй малчдын тоо			Үүнээс:				Архаг суурь өвчтэй хүний тоо
		Аймаг дотроо	Өөр сум аймагт	Өөр сум аймгаас ирж	Жирэмсэн эхийн тоо	0-5 насны хүүхдийн тоо	Өндөр настны тоо (75-аас дээш)	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо	
1	.....	0							
2		0							
3		0							
4		0							
5		0							
6		0							
	<b>Нийт</b>	<b>0</b>							

Бусад: (Шаардлагатай тохиолдолд өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой зарим сум, баг, аймгийн нутаг, дэвсгэр, хүн амын эрүүл мэндэд тулгамдсан асуудлаар энд нэмэлтээр бичнэ үү.)

**СУДАЛГААНЫ АСУУМЖ ХОЁР. ТУЛГАМДСАН АСУУДАЛ**

№	Аймаг	Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц		Төвлөрсөн халуун дулаан, хангах системийн байдал		Түлшний хангалт		Түргэн тусламжийн автомашины тоо		Шатахууны хүрэлцээ	
		Хэвийн (+,-)	Нэмэлт нөөц шаардлага тай тоо хэмжээ	Хангалт тай (+,-)	1. Өр үүссэн эсэх 2. Нэмэлтээр шаардлагат ай хэмжээ(л)	Одоо ашиглаж байгаа тоо	Дутуу тоо	Хэвийн (+,-)	Нэмэлт шаардлагатай тоо хэмжээ (литр)		
1		ЭМС-ын А/388 дугаар тушаалд заасан эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц									
		3 сарын нөөцтэй (+,-)	Дутагдалтай (+)	Одоо нэмэлт шаардлага тай тоо хэмжээ							
	<b>Нийт</b>										

Бусад: (Шаардлагатай тохиолдолд өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой зарим сум, баг, аймгийн нутаг, дэвсгэр, хүн амын эрүүл мэндэд тулгамдсан асуудлаар энд нэмэлтээр бичнэ үү.)

---ooOoo---